

✓

**ХОВД АЙМГИЙН БУЯНТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ЛУВСМАА ОВОГТОЙ ТӨРМӨНХИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

ТӨРӨЛХ НУТГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ТҮМЭНТЭЙГЭЭ ХАМТДАА

ЭРХЭМ ЗОРИЛГО: БУЯНТ НУТГИЙН ОЛОН ҮНДЭСТЭН, ЯСТАН ИРГЭДИЙНХЭЭ ХӨДӨЛМӨРЧ БҮТЭЭЛЧ УЛАМЖЛАЛ, ГАЗАР ШОРОО БАЙГАЛИЙН БАЯЛАГ, НӨӨЦӨД ТҮШИГЛЭН, ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЖ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХӨГЖСӨН, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАСАН ЖИШИГ СУМ БОЛНО.

Хэрэгжүүлэх зарчим

1. Буянтын ирээдүй – Хүүхэд хөгжил
2. Буянтын хөгжил – Ажилтай , орлоготой өрх гэр
3. Буянтын брэнд – Цэвэр хүнс
4. Буянтын бахархал – Ахмад үе
5. Буянтын нүүр царай – Ил тод, үүрэгжсэн нийтийн алба

Зорилт 1.Боловсрол соёлын талаар

1.Боловсрол, соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, Буянтын ирээдүй хүүхэд хөгжил бодлого хэрэгжүүлнэ.

2.“Хүүхэд хөгжлийн төв” байгуулж, хүүхэд бүрийн авьяас оюун ухааныг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх олон арга хэмжээ тогтмол зохион байгуулна.

3.Сумын түүх соёл, үндэстний музей, хүүхдийг хөгжүүлэх төв, ахмадын амралт сувиллын газрыг шинээр байгуулна.

4.Морин хуур, товшуур домборыг өрх бүрт залж, ахмад залуу үеийн урлаг соёлын залгамж халааг бэхжүүлж ажиллана.


5.Хүүхэд, залуучууд, ахмад, эмэгтэйчүүд , малчид, тариаланчдын чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулна.

6. Цагаан бургас, Наран хайрхан, Цагаан Эрэг, Нарийн гол багийн төвүүдийг халаалт, гэрэл цахилгаантай болгож, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.

7. Цагаан бургас, Нарийн гол багт жилд нэг удаа “Гэр цэцэрлэг” ажиллуулна.

Зорилт 2. Эрүүл мэндийн талаар эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлж хүн амын эрүүл мэндийн талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлнэ.

1. Орчин үеийн шаардлагатай оношилгооны техникээр хангаж ажиллана.



2. Эмийн бус эмчилгээний хэлбэрийг сумын эмнэлэгтэй хамтарч хэрэгжүүлнэ.
3. Чийрэгжүүлэлтийн танхимыг шинээр байгуулж, нийтийн биеийн тамир спортын арга хэмжээг улам өргөжүүлэн бүх нийтийн үйл хэрэг болгоно.
4. Явган аялал, дугуйн аяллыг архидалтгүй амьдралын хэвшил эрүүл мэндийн аянтай хоршуулан зохион байгуулж байна.
5. Хоол хүнсний эрүүл мэндэд онцгой анхаарч, цэвэр хүнсээр хангах ажлыг системтэйгээр хэрэгжүүлнэ.
6. Хөдөөгийн малчин иргэдийг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулна.

Зорилт 3. Хөдөө аж ахуйн талаар


1. Малын индексжүүлсэн даатгалын системийг нэвтрүүлж, ган зуд, гэнэтийн аюулаас хамгаалах эрсдлийн сантай болно.
2. Малжуулах хөтөлбөрийг цаашид улам өргөжүүлж малчид, иргэдтэй хамтран малын хулгайтай шинэлэг арга барилаар тэмцэнэ.
3. Ажлын байр урьд онуудаас нэмэгдүүлж ажиллана. Өрх бүр нэмэгдэл орлоготой болох нөхцлийг улам дээшлүүлнэ. Үүнд: зоорь, хүлэмжийн аж ахуй, жимс жимсгэнэ тариалах гэх мэт туслах аж ахуй хөгжүүлэхэд бодлогоор дэмжинэ.
4. Малыг үйлдвэр угсааг сайжруулах бодлогыг тусгайлан дэмжиж цөм сүрэг бий болгоно.
5. Сүү сүүн бүтээгдэхүүнээр хийх бүтээгдэхүүний нэр төрлийг улам нэмэгдүүлж ажиллана.
6. Үр тариа, тэжээлийн ургамал тариалах ажлыг дэмжиж, төмс хүнсний ногоо хадгалах, борлуулах сүлжээ бий болгоно.
7. “Буянтын брэнд” хөтөлбөр хэрэгжүүлж зах зээлд зарлан патентжуулах ажлыг хийнэ.
8. Малчин өрхүүдийг тариалангийн талбайтай болгон өрхийн үйлдвэрлэл эрхэлхэд бүх талаар дэмжлэг үзүүлнэ.

Зорилт 4. Дэд бүтцийн талаар Орон нутгийн тээврийн сүлжээ, зорчигч ачаа тээврийн аюулгүй байдлыг хангаж, “Зам дагаж хөгжил” гэдгийг амьдралд бүрэн утгаар нь хэрэгжүүлнэ.

1. Автобус, Микроавтобус, таксины зогсоол хийнэ.
2. Сумын төвийн гудамж, талбайг камержуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ

Зорилт 5. Нийгмийн хамгааллын талаар Хүн амын амжиргааны түвшинг дээшлүүлж, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох , эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг улам баталгаажуулна.

1. Ядуурал , ажилгүйдлийн шалтгааныг жил бүр судлан тогтоож, хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлж, зээл тусламжийн системийг хүртээмжтэй, оновчтой болгоно.
2. Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал амжиргааг дээшлүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэвтрүүлнэ. Үүнд: багийн иргэдийн дэмжлэгээр малжуулах, төмс хүнсний ногоо тариулах, туслах малчнаар ажиллуулах зэрэг байж болно.



[Handwritten signature]

Зорилт 6. Байгаль хамгаалах талаар

1. Байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах арга хэмжээг улам өргөжүүлнэ.
2. Сумын хэмжээнд хоггүй орчинд амьдрах нөхцлийг ард иргэдтэйгээ хамтран бүрдүүлнэ.
3. Нутаг, бэлчээрийг хуваарьтай ашиглах ажлыг иргэдийн хүчээр зохион байгуулна.
4. Байгалийн сонин тогтоцтой газар, уул ус, ан агнуур, түүх соёл, урлаг зэрэг бүх төрлийн аялал жуулчлал хөгжүүлэхийг дэмжиж ажиллана.
5. Нарийн гол, Цагаан бургас багийн байгалийн баялаг ашигласны төлбөрөөс байгаль хамгаалах сан бүрдүүлж ажиллана.
6. Бүх багийг орон тооны бус байгаль хамгаалагчтай болгоно.

Зорилт 7. Төрийн байгуулалт эрх зүйн хүрээнд

1. Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, нээлттэй болгож, орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөөх иргэний оролцоог нэмэгдүүлж, ил тод, үүрэгжсэн нийтийн албыг бий болгоно.
2. Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын байгууллагын дэргэд иргэний нээлттэй танхим байгуулж, төсөв санхүү, жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх, сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, иргэдэд газар өмчлүүлэх аливаа асуудлыг энэ танхимаар дамжуулан иргэдийнхээ саналыг авч ил тод, шударга шийдвэрлэдэг зарчимд шилжүүлнэ.
3. Иргэний зарын самбар, цахим мэдээллийн хуудас ажиллуулж, сумын ИТХ болон ЗДТГ – аас шийдвэрлэх гэж буй асуудлыг урьдчилан иргэддээ сонсгож, тэдний саналыг авч тусгах ажлыг хэрэгжүүлнэ.
4. Хөдөөгийн багуудын багийн эмч, багийн дарга, багийн иргэдийн нийтийн хурлын даргын хамтын ажиллагааг улам ойртуулж ажиллана.
5. Монгол улсын жишиг сум болж хөгжихийн төлөө бүх байгууллага, иргэдийн үйл ажиллагааг чиглүүлж ажиллана.



Ховд аймгийн Буянт сумын
Цагаан бургас багийн Иргэн
Лувсмаа овогтой Төрмөнх
Утас: 99438408, 86669480